



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2005 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

**Дүүргийн Засаг даргын Тамгын газрын
бүтэц, харьяа газруудын тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 1 дүгээр заалт, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар баталсугай.

1. Төрийн захиргааны хэлтэс /Иргэний бүртгэлийн тасагтай/
2. Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс
3. Нийгмийн хөгжлийн хэлтэс
- 4.Үйлдвэрлэл, тохижилт, үйлчилгээний хэлтэс
5. Цэргийн штаб
6. Аж ахуйн тасаг


Хоёр. Дүүргийн Засаг даргын тамгын газрын ажлын байр /албан тушаал/-ны үлгэрчилсэн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Дүүргийн Засаг даргын дэргэд дараах байгууллагуудыг ажиллуулсугай.

1. Газрын алба
2. Нийгмийн даатгалын хэлтэс
3. Гамшгаас хамгаалах штаб
- 4.Статистикийн хэлтэс
5. Татварын хэлтэс
6. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
7. Цагдаагийн хэлтэс
8. Замын цагдаагийн тасаг
9. Биеийн тамир, спортын хороо
10. Гэгээрэл хөгжлийн /Албан бус сургалтын/ төв
11. Эрүүл мэндийн нэгдэл
12. Тохижилт үйлчилгээний компани
13. Цэцэрлэг, сургуулийн хангамж, үйлчилгээний төв

Дөрөв. Засгийн газар, Нийслэлийн Засаг даргаас баталсан дүүргийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаар, бүтцийг чанд мөрдөж, дэргэдэх зарим байгууллагуудынхаа бүтэц, орон тооны хязгаарыг холбогдох газруудтай нь зөвшилцсөний үндсэн дээр тогтоохыг дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

Тав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2000 оны 423, 2003 оны 509 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Нийслэлийн Засаг даргын 2005 оны
1 дүгээр сарын 26... ны өдрийн
21 дүгээр... захирамжийн
хавсралт

**ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/НЫ
ҮЛГЭРЧИЛСЭН ЖАГСААЛТ**

Нэг. Удирдлага

1. Тамгын газрын дарга бөгөөд Төсвийн өрөнхий менежер

Хоёр. Төрийн захиргааны хэлтэс

1. Хэлтсийн дарга
2. Хүний нөөц, шагналын асуудал хариуцсан зохион байгуулагч
3. Төрийн захиргааны асуудал хариуцсан зохион байгуулагч
4. Тогтоол шийдвэрийн биелэлт, үнэлгээний асуудал хариуцсан зохион байгуулагч
5. Хороо хариуцсан зохион байгуулагч
6. Хуулийн зөвлөх, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үүрэг даалгаврын биелэлт хариуцсан зохион байгуулагч
7. Сургалт, эрх зүйн асуудал хариуцсан зохион байгуулагч
8. Засаг даргын туслах
9. Өргөдөл гомдол, эрэлт хүсэлт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан зохион байгуулагч
10. Хэвлэл мэдээлэл, гадаад харилцааны асуудал хариуцсан зохион байгуулагч
11. Архив, бичиг хэргийн эрхлэгч
12. Бичээч

А. Иргэний бүртгэлийн тасаг

1. Тасгийн дарга
2. Иргэний гэр бүлийн бүртгэлийн асуудал хариуцсан зохион байгуулагч
3. Иргэний бичиг баримт, шилжилт хөдөлгөөний асуудал хариуцсан зохион байгуулагч

Гурав. Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

1. Хэлтсийн дарга
2. Ерөнхий нягтлан бодогч
3. Төсвийн мэргэжилтэн
4. Бүртгэлийн мэргэжилтэн
5. Орлого, эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
6. Банкны төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн
7. Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн /нормативт/

Дөрөв. Нийгмийн хөгжлийн хэлтэс

1. Хэлтсийн дарга
2. Боловсролын асуудал хариуцсан зохион байгуулагч
3. Эрүүл мэнд, биеийн тамирын асуудал хариуцсан зохион байгуулагч
4. Хөдөлмөр эрхлэлт, халамж, хамгааллын асуудал хариуцсан зохион байгуулагч
5. Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан зохион байгуулагч
6. Хүүхэд, залуучууд, соёл, урлагийн асуудал хариуцсан зохион байгуулагч

Тав. Үйлдвэрлэл, тохижилт, үйлчилгээний хэлтэс

1. Хэлтсийн дарга
2. Хүнс, нийтийн хоолны үйлчилгээ хариуцсан зохион байгуулагч
3. Хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал хариуцсан зохион байгуулагч
4. Жижиг, дунд үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ хариуцсан зохион байгуулагч
5. Тохижилт, нийтийн аж ахуй хариуцсан зохион байгуулагч
6. Дэд бүтэц, аялал жуулчлалын асуудал хариуцсан зохион байгуулагч

Зургаа. Цэргийн штаб

1. Штабын дарга
2. Тoo бүртгэл, нөхөн хангалтын асуудал хариуцсан офицер
3. Сургалт, иргэний хамгаалалтын асуудал хариуцсан офицер

Долоо. Аж ахуйн тасаг

1. Дарга
2. Ахлах нягтлан бодогч
3. Нярав
4. Үйлчилгээний ажилтнууд